



ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2017 оны 12 дугаар 21 сарын .

Дугаар.....

Мандалговь хот

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Ашигт малтмалын тухай хуулийн 42 дүгээр зүйлийн 42.1 дахь заалтын дагуу "Говь шоо" ХХК (цаашид "Компани гэх)-аас тухайн аймгийн байгаль орчинд серөг нелөө багатай үйл ажиллагаа явуулах болон орон нутгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэхэд бодит оролцоог бий болгох, ажлын байр нэмэгдүүлэхэд зохих дэмжлэг үзүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.
- 1.2. Энэ гэрээнд Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Газрын тухай хууль, Газрын хэвллийн тухай хууль, Байгаль орчны тухай хууль болон бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.
- 1.3. Энэхүү гэрээг холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд Дундговь аймгийн "Ашигт малтмалын талаар аймгаас баримтлах бодлого", "Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр"-үүдийг үндэслэн нэг талаас Дундговь аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Н.Эрдэнэ-Очир /цаашид А тал гэх/, нөгөө талаас "Говь шоо" ХХК-ний /улсын бүртгэлийн дугаар 9011020042, РД 5060338/ захирал Чимэддорж Ганбаатар /Цаашид Б тал гэх/ нар байгуулав.
- 1.4. Энэхүү гэрээ нь байгуулагдсанаас хойш 1 /нэг/ жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Хоёр. А талын хүлээх эрх, үүрэг

- 2.1. Б талд ашигт малтмалын орд газрыг ашиглах үйл ажиллагаа явуулахад холбогдох хууль, дүрэм журмын хүрээнд сум, орон нутгийн зүгээс шаардагдах бүхий л үйлчилгээ, дэмжлэг туслалцааг үзүүлэх
- 2.2. Ашигт малтмалын ашиглалтын үеийн аюулгүй байдлыг хангах, үйл ажиллагаа явуулах хэвийн орчин, нөхцлийг бурдүүлж өгөх
- 2.3. Б талаас аймаг, сумын хөгжилд оруулсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус (мөнгөн болон бусад хэлбэрээр) дэмжлэг, туслалцаа, хөрөнгө оруулалтын талаарх үнэн зөв мэдээллийг шаардлагатай тохиолдолд компанийн зөвшөөрөлтэйгээр сонирхсон этгээдэд гаргаж өгөх буюу орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж нийтэд мэдээлэх
- 2.4. Ашигт малтмал олборлох үйл ажиллагааг байгаль орчинд аль болох серег нелөөгүй технологиор явуулахыг дэмжих, олборлолтын үйл ажиллагаа явуулсны

улмаас эвдэрсэн газрыг нехөн сэргээх ажилд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавих

2.5. Аймаг, сумын хөгжилд оруулсан хөрөнгө оруулалт, хандив дэмжлэг туслалцааг төрийн сангаар дамжуулан авч, зарцуулалтыг жил бүр тооцож тайлан мэдээнд оруулан нээлттэй ил тод мэдээлэх

2.6. Ашигт малтмалын салбарын тухайн жилийн "Байгальд зэлтэй шилдэг" аж ахуйн нэгжийг шалгаруулж, алдаршуулахад тухайн компаний үзүүлэлтийг харьцуулан үзэж байх

Гурав. Б талын хүлээх эрх, үүрэг

3.1. Орон нутгийн төсөвт хуулиар хүлээсэн татвар, хураамжийг төлж, тайлан, мэдээг сум, аймгийн Татварын хэлтэст гаргаж өгч байх / ААНОАТатвар, ХАОАТатвар, АТӨЯХ-ийн албан татвар, нийгмийн даатгал, ЭМДаатгал болон газар, ус ашигласны төлбөр/

3.2. Олборлох үйлдвэр байгуулахдаа байгаль орчныг хамгаалах арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх

3.3. Олборлосон хүдрийг тээвэрлэхдээ аймгаас баталсан ашигт малтмал тээвэрлэх замын маршрутын дагуу тээвэрлэх. Цаашид хүдрийг хатуу хучилттай автозамаар тээвэрлэхээр тооцож, зураг, төсвийг хийлгэх, бусад ашигт малтмал олборлогч компаниудтай хөрөнгө нийлүүлж, зам барих асуудлыг шийдэх

3.4. Олборлосон хүдрийн тээвэрлэлтийг шаардалга хангасан орон нутгийн тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг иргэд, аж ахуйн нэгжтэй гэрээлэн гүйцэтгүүлэх

3.5. Уурхайн үйл ажиллагаатай холбоотой аливаа хангасан нийлүүлэлт /max, сүү, цагаан идээ, ажлын хувцас, багаж хэрэгсэл, харуул хамгаалалт гэх мэт/- ийг орон нутгийн малчин, үйлдвэрлэгч, аж ахуйн нэгжүүдээс авч байх

3.6. Ажлын байрны шаардлага хангасан тохиолдолд нийт ажиллагсадын 60%-иас доошгүй хувийг орон нутгийн иргэдээс авч зохих тувшиний ажиллуулах

3.7. Засгийн газрын 2016 оны 137 дугаар тогтоолын дагуу нийт ажиллагсадын 25%-иас илүүгүй тооны гадаадын иргэн ажиллуулах. Хэрэв илүү хэмжээгээр авч ажиллуулсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу ажлын байр тутамд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг сар бүр орон нутгийн төсөвт төлөх

3.8. Мөн иргэний бүртгэлийн тухай хуулийн 26.4 дэх заалтын дагуу өөр орон нутагт харьялагддаг иргэдийг 180-аас бага хоногоор тухайн аймагт ажиллахад түр оршин суугаар бүртгүүлэх

3.9. Аймаг, sumaас ажилд авсан иргэдтэй Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хөдөлмөрийн гэрээ байгуулж, цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийг төлөх

3.10. Энэхүү гэрээний хүчинтэй байх хугацаанд Б тал **10,000,000 /Арван сая/** төгрөгийн дэмжлэгийг хүүхдийн байгууллагын тоног төхөөрөмжийг сайжруулах, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжих, байгаль орчны сурталчилгааны төв ажиллуулах зэрэг зориулалтаар санхүүжилтийг бэлэн ба бэлэн бус хэлбэрээр аймаг, сумдын зохих хетэлбөрт үзүүлж ажиллана.

3.11. Байгаль, цаг уурын хүндэрэл тохиолдох үед зохих туслалцаа, дэмжлэг үзүүлэхэд аймагтай хамтран ажиллах

3.12. Ашиглалт, эзэмшлийн ойролцоо байгаа малчин өрхийн хашаа хороог нүүлгэх, худаг усны асуудлыг шийдвэрлэхэд харилцан тохиролцож шаардагдах хөрөнгийн туслалцаа үзүүлж ажиллах

- 3.13. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөг холбогдох хууль тогтоомжийн дагуу батлуулж ажиллах
- 3.14. Олборлолтын үйл ажиллагааны явцад химиин хорт бодис хэрэглэх, хадгалах зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу авах
- 3.15. Олборлолтын үйл ажиллагааныхаа жилийн тайланг тухай бүр аймгийн Засаг даргын тамгын газар болон Мэргэжлийн хяналтын газарт хургуулж байх

Дөрөв. Хамтран хүлээх үүрэг

- 4.1. Талууд нь энэхүү гэрээний дагуу хүлээсэн тус тусын эрх, үүргээ гэрээ хүчинтэй байх бүхий л хугацаанд бүрэн хэрэгжүүлж, биелүүлэх
- 4.2. Гэрээний аль нэг тал негөө талын бичгээр өгсөн зөвшөөрелгүйгээр гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй.
- 4.3. Хэрэв гэрээний аль нэг тал энэхүү Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах санал, хүсэлттэй бол энэ тухайгаа негөө талдаа 30 хоногийн өмнө бичгээр мэдэгдсэний үндсэн дээр харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

Тав. Гэрээг дүгнэх

- 5.1. Энэхүү гэрээний биелэлтийг дараа жилийн эхний улиралд хоёр тал дүгнэж байна.

Зургаа. Хариуцлага

- 6.1. Компани энэхүү гэрээг зерчсөн бол дараах арга хэмжээг зөрчлийн байдлаас хамааруулж, холбогдох хууль тогтоомжинд заасан эрх хэмжээнд авна.
 - 6.1.1. Хууль болон гэрээ зерчсөн үйлдлээ зогсоохыг Компаниас шаардах
 - 6.1.2. Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, цуцлуулах хүсэлтээ эрх бүхий этгээдэд уламжлах
- 6.2. Энэ тохиолдолд компанийн шүүхэд гомдол, нэхэмжлэлээ гаргах эрх хэвээр хадгалагдана.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ДҮНДГОВЬ АЙМГИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ДҮНДГОВЬ АЙМГИЙН ХОХБТХ-ИЙН
ДАРГА *Борис* Н.ЭРДЭНЭ-ОЧИР

Хаяг: Дундговь аймгийн
Засаг даргын Тамгын газар
Утас: 70592150
91915480
Факс: 70592150

"ГОВЬ ШОО" ХХК-НИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"ГОВЬ ШОО" ХХК-НИЙ ЗАХИРАЛ
Ч.ГАНБААТАР

Хаяг: УБ хот БГД 6-х хороо 10-р
хороолол 33 дугаар байр
Утас: 89747279
факс:gobishoo.8888@yahoo.com